



## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 07 өдөр

Дугаар A/54

Улаанбаатар хот

Г

Ажлын хэсэг томилох тухай

Г

Гамшигаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг явагдах болсонтой холбогдуулан улсын үзлэгт шалгуулах бэлтгэл ажлыг ханганд ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баттулга Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа

Гишүүд:

С.Содонтуяа Хүний нөөц, бие бүрэлдэхүүний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа,

Р.Мөнхбат Дотоод ажил, төлөвлөлт, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, хошууч,

Э.Энх-Амгалан Гамшигаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад,

Б.Мягмаржав Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, ахмад,

Л.Батсайхан Компьютер, программ хангамж, кибер аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч,

Э.Оргил Сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч,

Ө.Мөнх-Отгон Төлөвлөлт, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, дэслэгч,

М.Хэрлэнтүяа

Эдийн засагч, дэслэгч,

Нарийн бичиг:

А.Тунгалаг

Бичиг хэрэг-архивын эрхлэгч, ахлах ахлагч,

2. Бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллахыг ажлын  
хэсгийн ахлагч, дэд хурандаа Б.Баттулгад үүрэг болгосугай.

ДАРГА,  
ХУРАНДАА

Ж ЧҮЛТЭМСҮРЭН

